



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 4 өдөр

Дугаар 402

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэхь заалт, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн “Капитал Маркет Корпораци ҮЦК” ХХК-ийн М.Мэргэнбаатарт үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан гишүүн ҮЦК-ийн ажилтанд Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. “Капитал Маркет Корпораци ҮЦК” ХХК-ийн ажилтан М.Мэргэнбаатарт үнэт цаасны арилжаанд оролцох эрхийн үнэмлэх олгох ажил зохион байгуулахыг Захиргаа аж ахуйн алба /Ж.Нарантуяа/-д, арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Арилжааны алба /Б.Чингүнжав/-д тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.АЛТАЙ